



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.2 дахь хэсэг нэмсүгэй:

“12.2.Энэ хуулийн 12.1.1-д заасан иргэнд тэтгэвэр олгоход Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан насыг баримтална.”

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт:

“12.1.1.65 насанд хүрсэн иргэн;”

2/27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг:

“27.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сум, хорооны Засаг даргын санал болгосноор аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга батална.”

3/27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэг:

“27.6.Зөвлөлийн үйл ажиллагаанд сум, хорооны Засаг дарга, аймаг дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга хяналт тавьж ажиллана.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР